БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/166/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Назгүл<br>Утас: 99427301 Цахим хаяг:nazguld@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........14
3. Аудитын тайлан........15
3.1 Ерөнхий зүйл ........15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........16
3.4 Материаллаг байдал ........16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........18
3.8 Аудитын гол асуудал ........18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........19
4. Аудитын илрүүлэлт ........19
4.1 Залруулсан алдаа........19
4.2 Төлбөрийн акт........19
4.3 Албан шаардлага ........20
4.4 Зөвлөмж ........20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.09 № 28

танай ______ -ны № ______ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-Дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,046,866.26** | **48,607,036.90** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 37,046,866.26 | 48,607,036.90 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,973,798.00 | 19,767,213.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,908,218.00 | 17,837,573.00 |
| 35130 | Эм боох материал | 2,065,580.00 | 1,929,640.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,073,068.26 | 28,839,823.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 288,200.00 | 175,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,165,618.00 | 26,196,808.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 678,000.00 | 718,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,281,052.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 1,231,100.00 | 1,297,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,393,098.26 | 452,715.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 36,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **165,895,126.02** | **156,001,820.78** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 165,895,126.02 | 156,001,820.78 |
| **392** | **Биет хөрөнгө** | 123,187,126.02 | 113,293,820.78 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 21,683,256.70 | 21,683,256.70 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (2,792,941.44) | (4,189,412.16) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 153,550,354.27 | 153,550,354.27 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (102,767,021.72) | (114,211,465.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 62,542,508.00 | 76,182,208.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (32,530,150.97) | (41,015,411.63) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,562,530.00 | 27,962,530.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,220,208.82) | (10,827,038.48) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 4,158,800.00 | 4,158,800.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 42,708,000.00 | 42,708,000.00 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,417,692.31) | (6,417,692.31) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 42,708,000.00 | 42,708,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **202,941,992.28** | **204,608,857.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **202,941,992.28** | **204,608,857.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 202,941,992.28 | 204,608,857.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 126,241,246.90 | 126,241,246.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 126,241,246.90 | 126,241,246.90 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 57,694,912.25 | 59,361,777.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 57,694,912.25 | 57,694,912.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,666,865.40 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 19,005,833.13 | 19,005,833.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **202,941,992.28** | **204,608,857.68** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **583,476,961.00** | **630,514,065.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,598,261.00** | **16,093,565.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 19,598,261.00 | 16,093,565.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 14,598,261.00 | 13,405,565.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | 150,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 14,448,261.00 | 13,255,565.00 |
| 120009 | Бусад орлого | 5,000,000.00 | 2,688,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **563,878,700.00** | **614,420,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 560,278,700.00 | 600,920,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 555,988,700.00 | 594,520,600.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 4,290,000.00 | 6,399,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,600,000.00 | 13,500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,600,000.00 | 13,500,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **611,542,213.75** | **628,847,199.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **611,542,213.75** | **628,847,199.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 610,885,413.75 | 622,815,620.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 439,547,100.00 | 465,156,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 278,656,200.00 | 288,338,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 157,890,900.00 | 174,045,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,000,000.00 | 1,188,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.00 | 1,584,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,200,100.00 | 10,175,920.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,200,100.00 | 10,175,920.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,681,310.00 | 48,710,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,193,300.00 | 9,701,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,338,010.00 | 28,554,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,150,000.00 | 6,954,600.00 |
| 210304 | Байрны түрээс | | 3,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,267,538.90 | 28,298,732.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,181,610.00 | 1,632,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,661,030.00 | 14,930,852.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,861,300.00 | 3,279,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 40,000.00 | 89,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,043,804.90 | 2,093,650.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,479,794.00 | 6,271,980.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,899,469.64 | 30,394,322.36 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 490,620.00 | 430,840.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,408,849.64 | 29,963,482.36 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,539,060.00 | 6,445,140.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,539,060.00 | 6,445,140.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 556,000.00 | 1,039,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 556,000.00 | 1,039,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,650,800.00 | 6,940,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,886,300.00 | 5,224,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 264,400.00 | 237,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,100.00 | 128,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,544,035.21 | 25,656,305.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,635,000.00 | 1,479,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 282,000.00 | 243,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,627,035.21 | 23,933,005.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 656,800.00 | 6,031,579.46 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 246,800.00 | 159,600.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 246,800.00 | 159,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 410,000.00 | 5,754,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 410,000.00 | 5,754,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 117,979.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 117,979.46 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(28,065,252.75)** | **1,666,865.40** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 4,151,042.11 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 4,151,042.11 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (4,151,042.11) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(32,216,294.86)** | **1,666,865.40** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **57,694,912.25** | 202,941,992.28 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **57,694,912.25** | 202,941,992.28 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **57,694,912.25** | 202,941,992.28 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | 1,666,865.40 | 1,666,865.40 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **126,241,246.90** | **19,005,833.13** | **59,361,777.65** | 204,608,857.68 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **564,738,700.00** | **610,858,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,150,000.00** | **2,838,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,150,000.00 | 2,838,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 150,000.00 | 150,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | 150,000.00 |
| 120009 | Бусад орлого | 5,000,000.00 | 2,688,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **559,588,700.00** | **608,020,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 555,988,700.00 | 594,520,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 555,988,700.00 | 594,520,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,600,000.00 | 13,500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,600,000.00 | 13,500,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **561,184,100.00** | **603,218,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **561,184,100.00** | **603,218,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **560,527,300.00** | **598,531,220.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 439,547,100.00 | 466,500,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 278,656,200.00 | 289,682,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 157,890,900.00 | 174,045,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,000,000.00 | 1,188,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.00 | 1,584,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,200,100.00 | 10,175,920.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,200,100.00 | 10,175,920.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,708,100.00 | 48,532,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,193,300.00 | 9,701,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,364,800.00 | 28,376,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,150,000.00 | 6,954,600.00 |
| 210304 | Байрны түрээс | | 3,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,461,600.00 | 18,792,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,066,200.00 | 972,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,925,800.00 | 13,827,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,861,300.00 | 3,279,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 89,600.00 | 89,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 518,700.00 | 622,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,551,200.00 | 26,567,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 627,700.00 | 544,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,923,500.00 | 26,023,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,094,400.00 | 8,261,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,365,400.00 | 3,296,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,729,000.00 | 4,965,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 556,000.00 | 1,039,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 556,000.00 | 1,039,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,650,800.00 | 6,940,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,886,300.00 | 5,224,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 264,400.00 | 237,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,100.00 | 128,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,758,000.00 | 11,723,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,476,000.00 | 11,479,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 282,000.00 | 243,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **656,800.00** | **4,687,579.46** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 246,800.00 | 159,600.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 246,800.00 | 159,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 410,000.00 | 4,410,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 410,000.00 | 4,410,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 117,979.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 117,979.46 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,554,600.00** | **7,639,800.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,554,600.00** | **7,639,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,554,600.00** | **7,639,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,554,600.00 | 7,639,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,554,600.00 | 7,639,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,554,600.00)** | **(7,639,800.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 594,670,600.00 | 594,552,620.54 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 594,670,600.00 | 594,552,620.54 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 592,789,000.00 | 592,671,020.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 466,500,000.00 | 466,500,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 289,682,400.00 | 289,682,400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 174,045,600.00 | 174,045,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,188,000.00 | 1,188,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,584,000.00 | 1,584,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,293,900.00 | 10,175,920.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,293,900.00 | 10,175,920.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,032,200.00 | 45,032,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,701,400.00 | 9,701,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,376,200.00 | 28,376,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,954,600.00 | 6,954,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,792,400.00 | 18,792,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 972,300.00 | 972,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,827,800.00 | 13,827,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,279,800.00 | 3,279,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 89,600.00 | 89,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 622,900.00 | 622,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,567,100.00 | 26,567,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 544,000.00 | 544,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,023,100.00 | 26,023,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,901,100.00 | 15,901,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,936,000.00 | 10,936,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,965,100.00 | 4,965,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,039,000.00 | 1,039,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,039,000.00 | 1,039,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,940,000.00 | 6,940,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,224,000.00 | 5,224,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 237,900.00 | 237,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,100.00 | 128,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,723,300.00 | 1,723,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,479,400.00 | 1,479,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 243,900.00 | 243,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,881,600.00 | 1,881,600.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 159,600.00 | 159,600.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 159,600.00 | 159,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,722,000.00 | 1,722,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,722,000.00 | 1,722,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 594,670,600.00 | 594,552,620.54 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 594,520,600.00 | 594,402,620.54 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 594,520,600.00 | 594,402,620.54 |

| | | | |
|---|---|---|---|
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 150,000.00 | 150,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | 150,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 35.00 | 34.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 34.00 | 33.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **35.00** | **34.00** |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 35.00 | 34.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13,500,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,500,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 13,500,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,500,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 13,500,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,500,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Алгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хорих ял эдлүүлэх чиглэлээр шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр болон бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

2021 онд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил болгох" зорилго, зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс ажилладаг. Тус хэлтэс нь харъяа байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлыг арилгаж, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг

хангах, анги, байгууллагын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлдэг байна.

Тус газарт 2021 онд дотоод аудитын шалгалт ирээгүй бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 611.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр буюу 0.8. хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.00 |
| Бараа материал | 37,046.9 | 48,607.0 | 11,560.1 |
| Үндсэн хөрөнгө | 165,895.1 | 156,001.8 | -9,893.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **202,941.9** | **204,608.8** | **1,666.9** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 202,941.9 | 204,608.8 | 1,666.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **202,941.9** | **204,608.8** | **1,666.9** |

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.6 сая төгрөг болж 11.5 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 62.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 13.3 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 58.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 6.3 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 156.0 сая төгрөг болж 9.8 сая төгрөгөөр буурчээ. Тайлант онд 7.6 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 6.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, үндсэн хөрөнгөнд 23.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 204.6 сая төгрөг болж 1.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1.7 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 630.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 47.0 сая төгрөгөөр буюу 8.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого, хөрөнгийн санхүүжилтийн орлого байна. Урсгал санхүүжилт өмнөх оноос 38.5 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилт 9.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 17.3 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Цалин, байр ашиглахтай холбоотой зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд өмнөх оноос нэмэгдэж, хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 547.2 сая төгрөг, тодотгосон төсөв 594.7 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 47.4 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 36.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.2 сая, байр ашиглахтай холбоотой зардлыг 1. 2 сая,нормативт зардлыг 0.9 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний

төлбөр, хураамжийн зардлыг 2.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.3 сая, урсгал шилжүүлгийг 1.2 сая, нийт 49.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлыг 1.4 сая, томилолт зочны зардлыг 0.4 сая, төгрөгөөр буюу нийт 1.8 сая төгрөгөөр анх баталсан төсвөөс бууруулж тодотгосон буюу нийт төсвийг анх баталсанаас 47.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Шалтгаан нь: Тус байгууллага нь тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага ба оны эхэнд цалин тогтоолтоор ажилчдын бүтэц орон тоо нэмэгдсэн, цол, төрийн тусгай алба хаасны нэмэгдэл, цалингийн шатлал нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлээ тодотголоор нэмэгдүүлж батлуулж авсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 594.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 594.5 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төсвийг нийт дүнгээр 0.1 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлт байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 13.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч байрны түрээсийн зардалд 3.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 10.0 сая, нийт 13.5 төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 115 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад алдаа зөрчил илрээгүй, хугацаа хоцроосон мэдээллийг нөхөж байршуулсан ба мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>